

ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ (2023 оны I улирлын түүвэр судалгааны тайлан)

Судалгааны товч үр дүн

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөллийн судалгааг 2023 оны 2 сарын 24-ний өдрөөс 3 сарын 7-ны өдрийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар болон судалгааны байгууллагуудын нийт 27 судлаачид (цаашид шинжээч)-ын дунд явууллаа. Мөн энэ улирлаас эхлэн Санхүүгийн зохицуулах хороотой хамтран Ард менежмент, Мандал ассет менежмент ҮЦК, Ди Би Эм ассет менежмент, Эрдэнэс ассет менежмент зэрэг томоохон хөрөнгө оруулалтын менежментийн компаниудыг түүвэр судалгаанд хамруулж эхэлсэн бөгөөд судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

Шинжээчид:

2023 оны I улиралд

- Инфляц бага зэрэг өсөж 12.5%,
- Эдийн засгийн өсөлтийг бага зэрэг буурч 3.9%,
- Төв банкны бодлогын хүү өнөөгийн түвшинд тогтвортой байж 13.0%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд тогтвортой байж 16.1%,
- Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг суларч 3,537.3 төгрөг болно гэж таамагласан байна.

2023 оны эцэст

- Инфляц буурч 11.4%,
- Эдийн засгийн өсөлтийг өнөөгийн түвшинд 4.7%,
- Төв банкны бодлогын хүү бага зэрэг буурч 12.6%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд тогтвортой байж 16.0%,
- Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг нэлээд суларч 3,743.8 төгрөг болно гэж таамагласан байна.


Хүснэгт 1.1 Судалгааны нэгдсэн үр дүн

Огноо	2023 он 1 сар	2023 он I улирал	2023 оны эцэс
Инфляц /ХҮИ-ийн жилийн өсөлт, УБ хот, %/	12.0%	12.5%	11.4%
Эдийн засгийн өсөлт /Бодит ДНБ-ий жилийн өсөлт, %/	4.8%	3.9%	4.7%
Төв банкны бодлогын хүү /%/	13.0%	13.0%	12.6%
Олгосон зээлийн дундаж хүү, /төгрөг, %/	16.1%	16.1%	16.0%
Валютын ханш /Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, хугацааны эцэст/	3,488.7₮	3,537.3₮	3,743.8₮

I. Инфляцын төсөөлөл


Шинжээчид инфляцыг 2023 оны I улиралд дунджаар 12.5%, хамгийн ихдээ 15.0%, хамгийн багадаа 10.4% байхаар төсөөлсөн байна. Цаашид инфляц буурч 2023 оны эцэст 11.4% гэж таамагласан байна (Зураг 1).

Зураг 1. Инфляц /таамаглал, жилийн хувиар/




Инфляцын таамаглалыг магадлалт тархалтаар нь авч үзвэл 2023 оны I улиралд инфляцын түвшин 12.0%-12.9% байх магадлал хамгийн өндөр буюу 32.9%-тай байна. 2023 оны эцэст инфляц 12.0%-12.9% байх магадлал мөн хамгийн өндөр буюу 22.8%-тай байна (Зураг 2).

Зураг 2. Инфляцын таамаглалын магадлалт тархалт /2023.I-IV улирал/



Шинжээчид 2023 оны I улирлын инфляцыг өмнөх 3 улирлын макро эдийн засгийн төсөөлөл (МЭЗТ)-ийн судалгааны үр дүнгүүдтэй харьцуулахад 1.9%-0.4%-аар буурч, хамгийн бага түвшинд (12.5%) байхаар таамагласан байна. 2022 оны I улирлын түүвэр судалгаагаар инфляц аажмаар буурсаар 12.9%-д хүрнэ гэж төсөөлж байсан нь 2023 оны I улирлын төсөөллөөс 0.4 нэгж хувиар өндөр үзүүлэлт байсан байна (Зураг 3).


Зураг 3. Өмнөх улирлуудын инфляцын таамаглалын харьцуулалт /жилийн хувиар/



II. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл


Шинжээчид бодит ДНБ-ий өсөлтийг 2023 оны I улиралд дунджаар 3.9%, хамгийн ихдээ 6.8%, хамгийн багадаа 1.0%-тай байхаар төсөөлж байна. Цаашид эдийн засгийн өсөлт нэмэгдэн 2023 оны эцэст өнөөгийн түвшинд (4.7%) хүрнэ гэж таамагласан байна (Зураг 4).

Зураг 4. Бодит ДНБ-ий өсөлт /таамаглал, жилийн хувиар/




Таамаглалыг магадлалт тархалтаар нь авч үзвэл 2023 оны I улиралд бодит ДНБ-ий өсөлт 4.0%-4.9% байх магадлал хамгийн өндөр хувьтай (25.1%) байна. 2023 оны эцэст 4.0%-4.9% байх магадлал мөн хамгийн өндөр хувьтай (26.4%) байна (Зураг 5).

Зураг 5. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын магадлалт тархалт /2023.I-IV улирал/



Шинжээчид 2023 оны I улирлын эдийн засгийн өсөлтийг өмнөх 3 улирлын макро эдийн засгийн төсөөлөл (МЭЗТ)-ийн судалгааны үр дүнгүүдтэй харьцуулахад 1.3%-0.1%-аар өсөж, хамгийн өндөр түвшинд (3.9%) байхаар таамагласан байна. 2022 оны I улирлын түүвэр судалгаагаар эдийн засгийн өсөлт -3.9%-аас хурдасч 2.6%-д хүрнэ гэж эерэгээр төсөөлж байсан нь 2023 оны I улирлын төсөөллөөс 1.3 нэгж хувиар бага байсан байна (Зураг 6).


Зураг 6. Өмнөх улирлуудын бодит ДНБ-ий таамаглалын харьцуулалт /жилийн хувиар/



III. Бодлогын хүүний төсөөлөл


Шинжээчид төв банкны бодлогын хүүг 2023 оны I улиралд дунджаар 13.0%, хамгийн ихдээ 14.0%, хамгийн багадаа 12.0% байна гэсэн хүлээлттэй байна. Цаашид бодлогын хүү бага зэрэг буурч 2023 оны эцэст 12.6% байна гэж таамагласан байна (Зураг 7).

Зураг 7. Бодлогын хүү /таамаглал, хувиар/



Бодлогын хүүний таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2023 оны I улиралд бодлогын хүү 13.0% байна гэсэн таамаглалтай байна (Зураг 8).


Зураг 8. Бодлогын хүүний таамаглалын тархалт /2022.IV улирал, хариултын тоогоор/



IV. Зээлийн хүүний төсөөлөл


Шинжээчид төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүүг 2023 оны I улиралд дунджаар 16.1%, хамгийн ихдээ 16.7%, хамгийн багадаа 15.4%-тай байна гэжээ. Цаашид зээлийн хүү харьцангуй тогтвортой байж 2023 оны эцэст 16.0% орчим байхаар таамагласан байна (Зураг 9).

Зураг 9. Зээлийн хүү /таамаглал, жилийн хувиар/



Зээлийн хүүний таамаглалын тархалтаас харвал 2023 оны I улиралд зээлийн жигнэсэн дундаж хүүг 16.0%-16.4% байна гэсэн таамаглал давамгайлж байна (Зураг 10).


Зураг 10. Зээлийн хүүний таамаглалын тархалт /2022.IV улирал, хариултын тоогоор/



V. Валютын ханшийн төсөөлөл

Шинжээчид 2023 оны I улиралд төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларч дунджаар 3,537.3 төгрөг, хамгийн ихдээ 3,618.1 төгрөг, хамгийн багадаа 3,500.0 төгрөг байна гэж үзжээ. Цаашид төгрөгийн ханшийн сулралт үргэлжилж 2023 оны эцэст 3,743.8 төгрөгт хүрнэ гэж таамаглажээ (Зураг 11).

Зураг 11. Ханш /таамаглал/



Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь ханш 2023 оны I улиралд 3,500.1-3,550.0 төгрөг байна гэж хариулжээ (Зураг 12).

Зураг 12. Ханшийн таамаглалын тархалт /2022.IV улирал, хариултын тоогоор/

